



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/004/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: siilegmaau@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	7-8
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Материаллаг байдал	9
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
4.4 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил, судалгааны үр дүн.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
5. Аудитын илрүүлэлт	11-12
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	12-13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.24 № 81

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН АХМАДЫН
ХОРООНЫ ДАРГА
Я.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ахмадын хорооны орон нутгийн төсвөөс олгож буй санхүүжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлж байгаа нь аймгийн Засаг даргын А/34 дүгээр захирамжаар төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх эрхийг ЗДТГ-ын даргад эрх шилжүүлсэн байна. Энэхүү эрх шилжүүлсэн захирамж нь аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн эрхийг ЗДТГ-ын нягтлан бодогчид шилжүүлэх үндэслэл болохгүй.

☎ 2125020215

ТЭЗ-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2-р гарын үсгийг ТШЗ-ийн нягтлан бодогч гүйцэтгэж байгаа нь хуульд нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болсон үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,957,610.61	1,150,960.16
1.1.6	Бараа материал	1,807,600.00	1,807,600.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,765,210.61	2,958,560.16
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,565,000.00	15,915,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,565,000.00	15,915,000.00
1.3	Нийт хөрөнгийн дүн	18,330,210.61	18,873,560.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	18,330,210.61	18,873,560.16
2.3.10	Өмнөх үеийн үр дүн		18,330,210.61
2.3.11	Тайлант үеийн үр дүн		543,349.55
2.3.12	Эздийн өмчийн дүн	18,330,210.61	18,330,210.61
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	18,330,210.61	18,873,560.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	112,423,000	86,201,480
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	112,423,000	86,201,480
8	Бусад орлого Хандив хөгжим		350,000
10	Ерөнхий ба удирдлагын зардал	100,186,607.53	86,008,130
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	12,236,392	543,350
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	12,236,392	543,350
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	12,236,392	543,350
24	Орлогын нийт дүн	12,236,392	543,350

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	112,423,000	86,201,480
1.1.6	Бусад мөнгөн орлого	112,423,000	86,201,480
1.2	Мөнгөн зарлагын дүн	106,191,706.53	86,008,130.45
1.2.1	Ажиллагчдад төлсөн	19,305,192.00	19,305,192.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	444,018.00	736,888.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,250,040.00	10,350,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,058,050.00	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,998,900.00	1,966,900.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн, томилолт	-	1,503,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	78,135,506.53	52,146,150.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,231,293.47	193,349.55
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		10,000,000.00
2.1	Мөнгөн орлогын дүн		
2.2	Мөнгөн зарлагын дүн		10,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,000,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,231,293.47	(9,806,650.45)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	4,726,317.14	10,957,610.61
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	10,957,610.61	1,150,960.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	18,330,210.61							18,330,210.61
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
2	Залруулсан үлдэгдэл								
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							543,349.55	543,349.55
4	Бусад дэлгэрэнгүй орлого								
5	Өмчид гарсан өөрчлөлт								
6	Зарласан ногдол ашиг								
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
8	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	18,330,210.61						543,349.55	18,330,210.61

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн ахмадын хороо нь ахмад настны эрх, ашиг сонирхлыг хамгаалж, олон нийтийн ажил, сайн дурын үйл ажиллагаанд ахмадуудыг татан оролцуулах, туршлага, мэдлэгийг нь нийгэмд түгээх, нийгмийн идэвхтэй амьдралыг дэмжихэд чиглэдэг чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд ахмад настны холбогдолтой төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхлэгч байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорнод аймгийн ахмадын хороо нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Ахмад настны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-д заасны дагуу Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, түүнд дагалдах санхүүгийн тайлангийн маягтын дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн ахмадын хороо нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй, мөрдөөгүйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буюу 35.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,957,610.61	1,150,960.16	-9,806,650.45
Бараа материал	1,807.600.00	1,807.600.00	00
Үндсэн хөрөнгө	5,565,000.00	15,915,000.00	10,350.000.00
Нийт хөрөнгө	18,330,210.61	18,873,560.16	543,349.55
Эздийн өмчийн дүн	18,330,210.61	18,873,560.16	4,934,160.16
Өр төлбөр ба цэвэр өмч	18,330,210.61	18,873,560.16	4,934,160.16

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15.9 сая төгрөг болж өссөн нь 10.3 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсантай холбоотой байна.

Эздийн өмчийн дүн 4.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Ахмадын тухай хуульд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгох хүрээнд аймгийн ИТХ-ын хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн баталсан 03/04 “Аймгийн 2025 оны батлагдсан төсөв” тогтоолын 3 дугаар заалтын 3.2.1.24-д аймгийн Ахмадын хороонд 74.4 сая төгрөгийг батлуулан хэрэгжүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 95.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 20.7 сая төгрөгөөр бууруулж, 74.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Ахмадын тухай хуульд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн 5 арга хэмжээний Төсвийн захирагчийн Орон нутгийн өөрөө удирдах ёсны удирдлагыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 74.4 сая төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 73.9 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт төсвийн 99.2 хувийг зарцуулж, 1.1 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,763.1	5,118.4	644.7	88.8%
2	Сургалт, семинар	1,000.0	1,000.0	0	100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	24,506.8	20,042.1	4,464.7	81.8%
4	Сум, багийн ахмадын даргын урамшуулал	41,598.0	41,598.0	0	100%

Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Уралдаан тэмцээн	1,500.0	6,119.1	-4,619.1	407.9%
		74,367.9	73,877.6	490.30	99.34

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 1.9 сая төгрөгийн шатахуун, 0.6 сая төгрөгийн бичиг хэрэг, 10.3 сая төгрөгийн тавилга эд хогшлын худалдан авалт хийсэн нь худалдан авах ажиллагаа зохион байгуулах төсөвт өртгийн дээд хязгаарт хүрээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Сийлэгмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нармандах, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн ахмадын хорооны 2025 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 96.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 74 мэдээллээс 74 мэдээллийг ил тод байршуулаагүй бөгөөд шилэн дансны цахим хуудсанд бүртгэлгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, зөрчлийг цаашид гаргахгүй зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн аймгийн ахмадын хорооны орон нутгийн төсвөөс олгож буй санхүүжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлж байгаа нь аймгийн Засаг даргын А/34 дүгээр захирамжаар аймгийн төсөв батлах тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, 4 дүгээр хавсралтаар баталсан аймгийн автозамын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх эрхийг ЗДТГ-ын дарга П.Бат-Өлзийд шилжүүлсэн байна. Энэхүү эрх шилжүүлсэн захирамж нь аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн эрхийг ЗДТГ-ын нягтлан бодогч П.Чимэгсүрэн шилжүүлэх үндэслэл болохгүй.

ТЭЗ-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2-р гарын үсгийг ТШЗ-ийн нягтлан бодогч гүйцэтгэж байгаа нь "Төсвийн тухай хууль"-ийн 19-р зүйлийн 19.2-т "Энэ хуулийн 14.1.3, 14.1.7, 14.1.11, 14.1.14, 14.1.15, 14.1.19-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ийн 3.1.2-т Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн Засаг дарга санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилно" 4.1-т "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч дор дурдсан үүрэг хүлээнэ:" гэсний 4.1.5-д "Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.4 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорил судалгааны үр дүн

МУ-ын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны хүрээнд Дорнод аймгийн ахмадын хорооны үйл ажиллагаанд хамаарал бүхий хэсэг байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангийн бүрэлдэхүүнд хамаарах төсөл арга хэмжээний хувьд холбогдох горим сорилыг хэрэгжүүлж дүгнэсэн бөгөөд зөрчил гараагүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дорнод аймгийн ахмадын хороо нь ТББ учир дараагийн аудитаар ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хувьд горим сорил хэрэгжүүлэх нь хуульд нийцэхээр байна. Ингэхдээ дараах асуудлуудад заавал горим сорил хэрэгжүүлж үнэлэх. Үүнд:

1. Санхүүгийн программ хангамж нэвтрүүлсэн байдал.
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.
3. Шилэн дансны нэгдсэн системд бүртгүүлж, хэрэгжүүлсэн байдал.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 4.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “үнэн зөв байх” гэсэн зарчмыг хангахгүй байна.

Аудитаар нийт 78.4 сая төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 74.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага нь ахмадын арга хэмжээний шагнал, урамшуулалд олгосон 3,890.0 мянган төгрөгийн орлогоос хувь хүний орлогын албан татварын 389.0 мянган төгрөгийг суутган төсөвт төвлөрүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”; гэж заасан бөгөөд энэ нь албан татвар ногдуулах зохицуулалттайг хэрэгжүүлэн ажиллаагүй.

5.2 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй. Мөн санхүүгийн тайланг санхүүгийн программ хангамж ашиглалгүйгээр хөтөлж байгаа нь санхүүгийн мэдээллийн бүрэн байдал, алдаа гарах магадлал нэмэгдэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн шаардлагын дагуу үнэн зөв гаргахад эрсдэл үүсэж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, санхүүгийн тайланг санхүүгийн программ хангамжаар гаргах.

2. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д " Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд бүртгүүлж, байгууллагын мэдээллийг баталгаажуулах, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллүүдийг shilendans.gov.mn цахим системд хуульд заасан хугацаанд, үнэн зөв байршуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг дутуу илэрхийлсэн	1	4,390.8			1	4,390.8	1	4,390.8				
Дүн	1	4,390.8	-	-	1	4,390.8	1	4,390.8	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шагнал, урамшуулалд олгосон 3,890.0 мянган төгрөгийн орлогоос хувь хүний орлогын албан татварыг суутган төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	389.0	1	389.0									
Санхүүгийн тайланг Сангийн сайдын баталсан заавар аргачлалын дагуу бэлтгээгүй байна.	1	0.0					1	0.0					
Дүн	2	389.0	1	389.0	-	-	1	0.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим системд бүртгүүлж, байгууллагын мэдээллийг байршуулаагүй	1	74,367.9					1	74,367.9					
Дүн	1	74,367.9	-	-	-	-	1	74,367.9	-	-	-	-	-

